

## БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН ТУХАЙ

Ж. Цэдэнсодном\*

Турк улс бол Европ, Ази тивийн уулзвар дээр оршдог, 56,4 сая хүн амтай, 805,7 мянган ам дөрвөлжин км газар нутагтай. Хүн амын бараг 90 хувь нь турк, бусад нь күрд, араб, грек, армян, гүрж үндэстэн. Нийслэл нь Анкара, албан хэл нь турк, хүн ам нь үндсэндээ лалын шашин шүтдэг.

БНТУ ардчилал, үндэсний онцлог, лалын шашны ёс уламжлалыг хослуулсан улс төр, нийгэм, соёлын өвөрмөц тогтолцоотой орон юм Туркийн хууль тогтоох дээд байгууллага Үндэсний Их Хурал 4 жилээр, ерөнхийлөгч нь 7 жилээр сонгогддог (Ерөнхийлөгч Т. Озал нас нөхчсөнтэй холбогдуулан 1993 оны 5 сард явуулсан ээлжит бус сонгуулиар ерөнхий сайд байсан Сулейман Демираль Туркийн ерөнхийлөгчөөр сонгогдов.) Гүйцэтгэн захирах дээд эрхийг ерөнхийлөгч, ерөнхий сайд нар эдэлнэ. Ерөнхий сайдыг Ерөнхийлөгч томилох бөгөөд тэрээр голдуу сонгуульд ялсан намын дарга байдаг. 1993 оны 6 дугаар сард ерөнхий сайдаар хатагтай Тансу Чиллер сонгогдов.

«Эх орны төлөө нам» 1983 оноос эхлэн бараг арав шахам жил засгийн эрхийг барихдаа улс орноо хөгжүүлэх талаар нэлээд дорвитой ажлыг хийсний үр дүнд эдийн засаг нь эрчимтэй хөгжиж, улсын дотоод байдал тогтвортой болсон. Гэвч 1990 оноос эдийн засгийн хөгжлийн зарим үзүүлэлт буурч, инфляц өссөн зэргээс 1991 оны парламентын сонгуульд «Зөв замын нам» ялж, «Ардын социал-демократ нам»-тай эвсэн засгийн газрыг байгуулан, улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийг тогтворжуулах программ боловсруулан хэрэгжүүлж байна. Уг программд үндэсний нийт бүтээгдэхүүний өсөлтийг тогтворжуулах, инфляцийг бууруулах, ард түмний аж амьдралын түвшинг дээшлүүлэх, амар амгалан, аюулгүй байдлыг хангах болон Үндсэн хууль тогтоомжийг Европын үйл явцын хандлагад нийцүүлэн шинэчлэхээр заажээ.

Туркийн эдийн засаг нь нэлээд хугацаанд хаалттай байсан бөгөөд сүүлийн 10 жилд зах зээлийн тогтолцоонд шилжсэнээр эрчимтэй хөгжиж, хөдөө аж ахуйн орноос аж үйлдвэр, ХАА-н орон болсон. Мөн гадаад худалдааны эргэлтийн дундаж өсөлтөөр Азийн дөрвөн «бар» аас ч дээгүүр байна. Турк улсаас бусад оронд зээл олгох боломжийн хэмжээ сүүлийн жилүүдэд өссөн бөгөөд шинээр тусгаар тогтносон Дундад Азийн орнуудад 1,2 тэрбум ам. долларын зээл олгохоор болжээ.

Турк нь чөлөөт бүс байгуулан хэрэгжүүлэхэд нэлээд амжилт олсон бөгөөд түүнийг хөгжүүлэх урамшуулалтын системийг боловсронгуй, өгөөжтэй болгосон тул гадаадын хөрөнгө оруулалт хэд дахинаар нэмэгдсэн ажээ.

Шинэ засгийн газар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтад таатай нөхцөлийг бүрдүүлэх, улс орны эдийн засагт чухал ач холбогдолтой хэд хэдэн том төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Тухайлбал Дундад Азийн Түрэг болон мусульман улсуудын дэд бүтцийг хөгжүүлэх төсөл, Хар далайн эдийн засгийн хамтын ажиллагааны төсөл, Израиль

\* Гадаад харилцааны яамны ажилтан

болон Арабын хойд хэсгийн газар тариаланг усаар хангах Эфрат төсөл зэргийг санхүүжүүлэхэд оролцохоор болжээ.

Туркийн аж үйлдвэрийн дотроос хөнгөн, барилга, уул уурхай, төмөрлөг, хүнсний үйлдвэр амжилттай хөгжсөн байна. Алт, мөнгө, зэс, хром, гянт болд, чулуун болон хүрэн нүүрс, төмрийн хүдэр олборлодог. Ширэм ган хайлуулах талаар багагүй амжилт олсон. Ашигт малтмалаараа дотоод үйлдвэрлэлийн хэрэгцээгээ бүрэн хангаад зогсохгүй хэтийн нэлээд нөөцтэй болно. Сүлжмэл, нэхмэл, барилгын материал, сантехник, эм, өргөн хэрэглээний бараа, арьс боловсруулах үйлдвэрлэл өндөр хөгжсөн.

Хөдөө аж ахуйн салбар мөн амжилттай хөгжиж байгаа бөгөөд жилд 20 сая гаруй тонн улаан буудай хураан авдаг. Үүгээрээ Европ тивд 11 байранд ордог. 90 сая орчим малтайгаас 60 сая гаруй нь бог болно. Эрдэнэ шиш, хасарваань, самар үйлдвэрлэх талаараа дэлхийд 1, хөвөн, тамхи, цайны үйлдвэрлэлээрээ Европт 11 байранд ордог.

Дотоодын хэрэгцээнд зориулан хөнгөн болон ачааны автомашин, автобус, өргөгч машин, вагоны зүтгүүр, суудлын болон ачааны вагон, далайн дунд оврын хөлөг онгоц, ХАА-н машин, цахилгаан техникийн хэрэгсэл, химийн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

Гадаадад голчлон барилга, хөнгөн, хими, хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргадаг. Хамгийн том түнш нь ХБНГУ, Итали, АНУ болон Ойрхи Дорнодын орнууд болно.

Турк улс НАТО-гийн идэвхтэй гишүүн бөгөөд цэрэг зэвсгийн үлэмж нөөцтэй, зэвсэглэлийн үйлдвэр хөгжсөн орон. Мөн Европын Зөвлөлийн гишүүн, ЕЭЗХН-ийн гишүүнээр 1987 онд элсэхийг хүссэн боловч тус нийгэмлэг уг асуудлыг хойшлуулсан бөгөөд одоо дахин яригдаж байна.

Европын хамтын нийгэмлэг, НАТО, АНУ, ТТУХН (ялангуяа Дундад Азийн мусульман шашинтай БНУ-ууд) Балкан болон Ойрхи Дорнодын улсуудтай харилцаагаа хөгжүүлэхэд илүү анхаарч байна. Гадаад орчинд сүүлийн үед гарсан эрс өөрчлөлтүүдийг соргоогоор мэдэрч, АНУ зэрэг холбоотныхоо цэрэг, улс төр, санхүүгийн дэмжлэг, туслалцаанд түшиглэн улс төр, эдийн засгийн нөлөөгөө бүс нутаг, орчин тойрондоо бэхжүүлэх, олон улсын нэр хүнд, улс төрийн жингээ дээшлүүлэх бодлого явуулж байна. Турк Персийн булангийн дайнд АНУ-ын талд туйлбартай зогсож, зэвсэг техникийн артал болж байсан хийгээд зөрчилдөж ирсэн Болгар, хөрштэйгээ эвлэрч, Өрнөд, Төв, Дорнод Европыг Араб ертөнцтэй холбох гүүр болохыг эрмэлзэн, Пантуркийн үзэл санаагаа аль нэг хэмжээгээр хэрэгжүүлэх боломж олж, Араб, Израиль болон Исламын аль ч урсгалын улс оронтой адил зай барин харилцаж байгаа зэрэг тодорхой байр суурь баримталж байгаа боловч үүнийгээ бүхэлд нь хэрэгжүүлэхэд туркийн хүчин чадал, хөрөнгө чинээ нь арай дийлэхгүй тул АНУ, Өрнөд Европ, Саудын Араб зэрэг орноос үзүүлэх санхүүгийн дэмжлэгт найдаж байгаа бөгөөд тэд ч түлхүү тусалж магадгүй. Грекээс бусад Балканы орнуудтай хэвийн харилцаатай болов. Турк 1974 онд Кипрт цэргийн хүчээр орж, улмаар 1983 онд Умард Киприйн Бүгд Найрамдах Турк Улс гэгчийг байгуулснаас хойш Кипр улс одоо болтол хуваагдмал хэвээр байна. Иймд Грек Туркийн маргаан цаашид ч үргэлжлэх төлөвтэй.

Сүүлийн үед Турк Дорнод, Европ, Азийн орнуудтай харилцаагаа хөгжүүлэхийг сонирхож байгаа нь Өрнөд Европын интеграчлагдах үйл явцад бүрэн орж чадаагүй, тэдгээр орнуудын зүгээс худалдаа, эдийн засгийн харилцаанд хязгаарлалт тавьдаг зэрэгтэй холбоотой гэж үздэг ажээ.

Турк, Иран, Пакистан анх эхлэн байгуулсан эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэг (ЭКО)-т их ач холбогдол өгч байгаа бөгөөд тус нийгэмлэгт Дундад Азийн мусульман шашинтай улсууд нэгдэн орсноос цаашид нэлээд өргөжиж, дээд түвшинд удаа дараа уулзан зөвлөлдөж байна.

### **Монгол, Туркийн харилцаа**

1969 оны 6 дугаар сарын 24-нд Монгол, Туркийн хооронд дипломат харилцаа тогтоосон. Үүнээс хойш хоёр тал 7 удаа элчин сайд нараа харилцан хавсарган томилж, Итгэмжлэх жуух бичгийг нь бариулаад байна.

Монгол, Турк нь газар зүйн хувьд алс зайдуу оршдог боловч хэдэн зуун жилийн тэртээгээс түүх, соёлын хэлхээ холбоотой байсан бөгөөд дэлхий дахинд нааштай өөрчлөлтүүд явагдан, манай оронд ардчилал, өөрчлөлт шинэчлэлийн үйл явц өрнөж, нээлттэй гадаад бодлого явуулах болсоны үр дүнд харилцааг хөгжүүлэх боломж нээгдэн, Монгол улстай харилцах Туркийн сонирхол өссөн зэргээс тус хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд идэвхжин хөгжих хандлагатай боллоо.

Туркийн Соёлын яамны сайдаас манай Засгийн газрын шадар сайд, СУХХ-ын дарга нарыг урьсаны дагуу Б. Бадарууган тэргүүтэй төлөөлөгчид 1991 оны 5 дугаар сард Туркт албан ёсны айлчлал хийх үеэр манай Засгийн газрын ерөнхий сайдаас Туркийн ерөнхий сайдад явуулсан илгээлт, шадар сайд Д. Дорлигжаваас Туркийн Соёлын Яамны сайдад илгээсэн захидлыг тус тус гардуулж, хоёр орны хооронд соёл, урлагийн салбарт 1991 — 93 онд хамтран ажиллах тухай протоколд гарын үсэг зурсан нь тус хоёр улсын соёлын харилцааг цаашид хөгжүүлэхэд төдийгүй монгол, Туркийн ард түмэн ойртон харилцахад чухал эхлэл болсон билээ.

Туркийн засгийн газрын урилгаар манай ГХ-ны сайд 1992 оны 5 дугаар сард Туркт албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр «Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ»-г үзэглэж, «Худалдаа, эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр», «Боловсрол, шинжлэх ухаан, соёл, спортын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр», «Дипломат болон албан паспорттай иргэд харилцан визгүй зорчих тухай хэлэлцээр», тэрчлэн цаашид байгуулвал зохих хэлэлцээр, протоколуудын талаарх тохиролцоонд тус тус гарын үсэг зурсан нь манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх зарим хууль зүйн гол үндэс суурийг тавьснаараа чухал ач холбогдолтой юм. Ийнхүү манай ГХ-ны сайд Туркт анх удаа айлчилсан нь хоёр орны харилцааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал алхам боллоо.

Монголын УИХ-ын дарга Н. Баганбанди тэргүүтэй төлөөлөгчид 1993 оны 9 дүгээр сард Туркийн Үндэсний Улсын Их Хурлын дарга Х. Жиндорукийн урилгаар Туркт албан ёсны айлчлал хийж, хоёр парламентын хоорондын хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурав. Мөн айлчлалын үеэр Туркийн ерөнхийлөгч С. Демирельд манай ерөнхийлөгчөөс илгээсэн албан ёсны урилгыг гардуулав. Энэхүү айлчлал нь зөвхөн хоёр парламентын хооронд холбоо тогтоосон төдийгүй хоёр талын харилцааг цаашид хөгжүүлэхэд чухал түлхэц болов.

Орхоны хөндийн хөшөө, дурсгалыг сэргээн засварлах, хамгаалах, талаар туркийн тал санхүүгийн туслалцаа үзүүлэн хамтран ажиллах асуудлыг харилцан ярилцаж байгаа болно. 1993 оны 11 дүгээр сард «Торгон зам» сэдвээр Туркт болох олон улсын бага хуралд манай

улсыг урьсан бөгөөд 7 дугаар сард Туркийн ерөнхий сайдын зөвлөх Култекин Озкан тэргүүтэй төлөөлөгчид манайд айлчилж, уг асуудлаар манай холбогдох хүмүүстэй санал солилцов.

1992 оны 6 дугаар сард туркийн тал хүмүүнлэгийн тусламж болгон 26 тн. хүнсний барааг 2 онгоцоор Улаанбаатарт хүргэж ирсэн.

Манай улсын үндэсний баяр-ардын хувьсгалын 71 жилийн ойн баяр наадамд Туркийн ерөнхий сайдын ахлах зөвлөх Н. Зейбек (хуучин Соёлын яамны сайд байсан) тэргүүтэй төлөөлөгчид ирж оролцсон бөгөөд тэрээр манай удирдах хүмүүстэй уулзах үеэр ярилцаж тохирсоны дагуу 1992 оны 10 сараас манай 18 оюутан Туркт сурч эхэлсэн бөгөөд 1993 оны хичээлийн жилд мөн 20 оюутан авахаар болсон.

Мөн Монголын мусульманы нийгэмлэгийн төлөөлөгчид 1991 оны эхээр Туркт айлчилж, Шашны хэрэг эрхлэх Яам, Соёлын яамны сайд нартай нь болон бусад хүмүүстэй уулзаж санал солилцсон. Тус нийгэмлэгийн шугамаар Туркт 1991 оноос хойш шашны болон бусад сургуульд 150 орчим хүүхэд төрөл бүрийн мэргэжлээр сурч байна.

Туркийн Төлөөлөгчид 1992 оны 9 дүгээр сард Монголд ирж, «Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих тухай хэлэлцээр»-ийн төслийг 1993 оны 6 дугаар сард манай төлөөлөгчид Туркт айлчилж, «Давхар татвар ногдуулахаас зайлсхийх тухай хэлэлцээр» ийн төслийг тус тус үзэглэв. Харин Туркийн Засгийн газрын Хэмжээний эдийн засгийн төлөөлөгчид 1993 оны 10 дугаар сард Монголд айлчилж манай холбогдох яам газрын удирдах хүмүүстэй уулзаж, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх талаар санал солилцсон байна. Мөн айлчлалын үеэр «Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх тухай» протоколд гарын үсэг зуржээ.

Ийнхүү манай улстай харилцаагаа өргөтгөх туркийн сонирхол өсч байгаа болон богино хугацаанд эдийн засаг нь үсрэнгүй хөгжсөн туршлага зэргийг нь харгалзна Турктэй Монгол улс бүх талын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэн хөгжүүлэхийн төлөө байна.

**МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ**

**КОЛЛЕЖ де ФРАНС**

Ц. Эрдэнэчимэг\*

Франц улс дэлхийн соёлт орны нэг билээ. Дэлхийн шинжлэх ухаан, соёл, урлагт үлэмж хувь нэмэр оруулсан гарамгай хүмүүс, шинжлэх ухаан, соёл, урлагийн уурхай болсон байгууллага Францад олон бий. Тэдгээрийн дотор олон зуун жилийн түүхтэй бөгөөд одоо ч үйл ажиллагаа нь улам бүр өргөжин тэлсээр байгаа байгууллага цөөнгүй байна. Шинжлэх ухааны тийм томоохон байгууллагын нэг нь Коллеж де Франс юм. Парис хотын төв хэсэгт эртний гоёмсог байшинд байрладаг энэ байгууллага нь Франц улсын эрдэм шинжилгээний газруудад хийгддэг суурь судалгааг удирдан зохицуулахын зэрэгцээ их сургуулийн дараах сургалтыг явуулах үүрэгтэй ажээ.

Төрийн ивээлд байдаг бөгөөд Боловсролын яамны сайд шууд хариуцдаг энэхүү Коллеж де Франс нь 1530 онд Францын ван I Франсуагийн санаачилгаар байгуулагдаж, анхандаа «Вангийн Коллеж» гэсэн нэртэй байгаад 1870 оноос «Коллеж де Франс» гэж нэрлэгдэх болсон байна.

Коллеж де Франсыг энэ байгууллагын ерөнхийлөгч толгойлох бөгөөд түүнийг гурван жилийн хугацаагаар сонгодог байна. Бүрэн эр-

\* ДДОУС-ын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан